

ЕВРОП ДАХЬ МОНГОЛЧУУДЫН ВОЛЕЙБОЛЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ

VII ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

2019.01.13

Берлин хот

Нэг. Ерөнхий зорилго

Европын холбооны улсад ажиллаж, амьдарч байгаа Монголчуудын дундах гар бөмбөгчдийг спортоор ойртон нөхөрлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, уг спортыг сурталчлах, өсвөрийн тамирчдыг бэлтгэх, ахмад тамирчдаас суралцахад гол зорилго оршино.

Хоёр. Тэмцээний зохион байгуулагчид, зохиогдох хугацаа, газар

Тэмцээнийг FairPlay - FairWorld - Спорт нөхөрлөл - Байгаль эх - уриан дор Герман улсын Берлин хотын "ЦОГ" спорт клуб Ерөнхий зохион байгуулагчаар ажиллах ба Монгол Улсаас ХБНГУ-д суугаа ЭСЯ болон Берлин дахь Монголын мэргэжил эзэмшигч болон оюутны холбоо ("MAS Berlin e.V."), Монголын волейболын холбооны Европ дах салбар зөвлөлтэй хамтран Монгол улс Герман улсын хооронд дипломат харилцаа үүссэний 45 жилийн ойн хүрээнд зохион байгуулна.

Тэмцээн 2019 оны 10 дугаар сарын 05-наас 06-нд Герман улсын Берлин хотын MAX SCHMELLING HALLE спорт цогцолборт болно.

Хаяг : Am Falkpl. 1, 10437 Berlin

Гурав. Тэмцээний насны ангилал баг тамирчид.

3.1 Насны ангилал

Эрэгтэйчүүд:

- Өсвөр үе, (18 хүртэлх буюу 2002 оны 1 сарын 1 нээс хойш төрсөн)
- Насанд хүрэгчид (Эцэг эхийн болон дасгалжуулагчийн зөвшөөрлийг үндэслэн насанд хүрээгүй тамирчинг багт оруулж тоглохыг зөвшөөрнө.)
- Мастер ангилал (40 наснаас дээш, 1979 оны 12 сарын 31 наас өмнө төрсөн)

Эмэгтэйчүүд:

- Өсвөр үе, (18 хүртэлх насны, 2002 оны 1 сарын 1 нээс хойш төрсөн)
- Насанд хүрэгчид (Эцэг эхийн болон дасгалжуулагчийн зөвшөөрлийг үндэслэн насанд хүрээгүй тамирчинг багт оруулж тоглохыг зөвшөөрнө.)
- Мастер ангилал (36 наснаас дээш, 1983 оны 12 сарын 31 наас өмнө төрсөн)

3.2 Багт 10 хүртэл тамирчид, 1 дасгалжуулагч байж болно.

3.3 Шагнал, мандатыг мэдүүлэгт байгаа тамирчдын тоогоор олгоно.

3.4 Нэг клубын 2 багийн дээд наснаас доод нас руу 2 хүртэл тамирчид шилжин орж тоглохыг зөвшөөрнө.

3.5 Тус тэмцээнд Европ тивд байнга оршин сууж буй, тухайн орондоо бүртгэлтэй Монгол иргэд оролцоно.

Дөрөв. Тэмцээний зохион байгуулалт, техникийн зөвлөгөөн

4.1 Тэмцээн ОУВХ-ны дүрмийн дагуу явагдана.

4.2 Техникийн зөвлөгөөн 2019 оны 10 сарын 4-ны 19 цагт Герман улс дахь Монгол улсын Элчин Сайдын яамны байранд болно.

Хаяг: Hausvogteipl. 14, 10117 Berlin

4.3 Тойргын тоглолтын дүн гаргахдаа хамгийн олон оноо авсан баг тэргүүлэх эрэмбийг баримтална. Тоглолтын 1 ба 2 дугаар үе 25 оноогоор, 3 дугаар үе 15 оноогоор явагдана.

- Тоглолтод баг 2:0 хожсон бол 2 оноо, хожигдсон бол 0 оноо авна.

- Тоглолтод баг 2:1 хожсон бол 1,5 оноо, хожигдсон бол 0,5 оноо авна.

- Тоглолтод оролцоогүй багт 0 оноо, эсрэг багт 2 оноо өгнө.

Тойргийн тоглолтын дүнг гаргахдаа дээрх оноогоор эрэмбэлэх ба 2 ба түүнээс дээш баг ижил оноо авсан бол ээлжийн \үе\ тоглолтын онооны харьцаагаар шийднэ.

4.4 Тэмцээний тоглох системийг оролцох багуудын тооноос хамааран Техникийн зөвлөгөөн дээр эцэслэн шийдвэрлэнэ.

4.5 Тэмцээн FairPlay - FairWorld - Спорт нөхөрлөл - Байгаль эх - уриан дор зохиогдож буйтай холбогдуулан тэмцээний үеэр нэг удаагийн сав баглаа боодол, хүнсний аяга, тавагзэрэг хэрэглээг хумих, өөрсдийн ус, ундааны саваа авч ирэх, нөхөн үрждэг байгалийн болон Fair Handel бүтээгдэхүүн ашиглахыг эрмэлзэнэ.

4.6 Тэмцээний үеэр спортын бус зан авир гаргасан тохиолдолд зохион байгуулах комисс тухайн баг, тамирчныг тэмцээнээс хасах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

4.7 Тэмцээний үеэр согтууруулах ундаа хэрэглэсэн тоглогчийг талбайгаас хөөж, дараагийн 2 тоглолтод оролцох эрхийг хасна.

4.8 Мэдүүлэгт ороогүй тамирчин тоглолтонд оролцсон нь нотлогдвол тус багийг тэмцээнээс хасна.

4.9 Нийт тэмцээнд оролцогчдод аяллын болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Тэмцээний эмч шүүгч тоглолтын үед гарсан бэртэл, гэмтэлд анхны тусламж үзүүлнэ.

4.10 Тэмцээнд оролцогч багууд тоглолтын жигд хувцастай, хувийн дугаартай байна.

Тав. Мандат олгох, багын хураамж, шагнал урамшуулал

5.1 Тэмцээнд оролцогч багуудын мэдүүлгийг 2019 оны 09 сарын 15-ны өдөр хүртэл маягтын дагуу info@tsog-berlin.de e-mail -р хүлээн авна.

5.2 Тэмцээнд зөвхөн мандат авсан тамирчид оролцоно. Тэмцээнд насанд хүрэгчид болон мастер ангилалд оролцох Баг тус бүр 150 еврогийн хураамж төлж тэмцээнд оролцоно. Өсвөрийн насны ангилалд хураамж авахгүй.

5.3 Тэмцээний хураамжийг 9 дүгээр сарын 20 дотор доорх дансанд шилжүүлсэн байна. Зохион байгуулалт, төлөвлөлттэй холбогдуулан гарч буй нэмэлт зардлаас шалтгаалан 9 дүгээр сарын 20-ноос хойш хураамжийг 200 Еврогоор тооцно.

Данс: MDWK e.V
Deutsche Bank
IBAN: DE08 1007 0024 0184 9850 00,
BIC(SWIFT-CODE): DEUTDE33HAN

5.4 Тэмцээнд насанд хүрэгчид болон мастер ангилалд байр эзэлсэн багуудад ангилал тус бүрт дараах байдлаар шагнал олгоно. Үүнд:

I байр - Аваргын цом, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал,
II байр - Мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал,
III байр - Хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал,
Шилдэг довтлогч - цом өргөмжлөл, мөнгөн шагнал,
Шилдэг холбогч цом өргөмжлөл, мөнгөн шагнал.

5.5 Өсвөрийн насны ангилалд оролцсон баг бүрд өргөмжлөл, дурсгалын зүйл гардуулна.

5.6 Мөнгөн шагналын санг тэмцээний хураамжаар цугласан мөнгөөр бүрдүүлэн дараах байдлаар зарцуулах ба үлдэгдэл мөнгийг зохион байгуулалтын бусад зардалд тооцно. Үүнд: 1-р байр шагналын сангийн 30%, 2-р байр шагналын сангийн 20%, 3-р байр шагналын сангийн 15% -ийг тус тус олгоно.

Зургаа. Тэмцээний нээлт, хаалт, хүндэтгэлийн арга хэмжээ

6.1 Нээлтийн ажиллагаа 2019 оны 10-р сарын 05-ны 12 цагт болно. Баг тамирчид тоглолтын хувцастай байх бөгөөд, төлөөлж буй орныхоо туг далбаа, багийн түүх амжилтыг харуулсан сурталчилгааг барихыг зөвшөөрнө. Нээлтийн үйл ажиллагааны тодорхой хөтөлбөрийг техникийн зөвлөгөөн дээр танилцуулна.

6.2 Тэмцээний дараах хүндэтгэлийн баяр, цэнгүүн 2019 оны 10 сарын 06-ны 18 цагт танхимд болно.

Хаяг: VIOLETTE FESTSAAL BERLIN, Markgrafenstraße 67, 10969 Berlin

**ТЭМЦЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ
БЕРЛИН ХОТЫН “ЦОГ” МОНГОЛ СПОРТ КЛУБ**



ЕВРОП ДАХЬ МОНГОЛЧУУДЫН ВОЛЕЙБОЛЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ VII ТЭМЦЭЭНИЙ МЭДҮҮЛЭГ

Улс :

Багийн нэр :

Харьяа клуб, холбоо :

Төрөл: /эрэгтэй, эмэгтэй, насны ангилал/

№	Овог нэр	Төрсөн он, сар, өдөр	Спортын цол, зэрэг	Биеийн өндөр	Хувийн дугаар	Тоглолтын үүрэг
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						

Манай баг тэмцээний журамтай цахим хуудаснаас уншиж танилцсан ба хүлээн зөвшөөрч байна.

Багын ахлагч: